



2020 оны 06 дугаар сарын 17
№23 /1125/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Гамшгаас хамгаалах тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Түр хороо байгуулах
тухай**

**Монгол Улсын
олон улсын
гэрээ**

**“Монгол Улсад COVID-19-аас
Урьдчилан сэргийлэх, хариу арга
хэмжээ авах, бэлэн байдлыг
хангах” төсөл**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

258.	Санхүүжилтийн болон зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай	1170
259.	Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1171
260.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1185
261.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1186
262.	Онц байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1186
263.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай	1187
264.	Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	1187

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

265.	“Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 39	1188
266.	Цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр батлах тухай	Дугаар 40	1188
267.	“Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 41	1189



268.	Цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр батлах тухай	Дугаар 42	1190
269.	“Зарим албан тушаалтны цалингийн хэмжээг тогтоох тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 43	1191
270.	“Цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр батлах тухай” тогтоолд нэмэлт оруулах тухай	Дугаар 44	1192
271.	Түр хороо байгуулах тухай	Дугаар 49	1193
МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ			
272.	“Монгол Улсад COVID-19-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төсөл		1194

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**САНХҮҮЖИЛТИЙН БОЛОН ЗЭЭЛИЙН
ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. “Монгол Улсад COVID-19-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн хүрээнд Монгол Улс, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр байгуулсан Санхүүжилтийн хэлэлцээр болон Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр байгуулсан Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г. ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.19-4.1.24 дэх заалт:

“4.1.19. “гамшгийн онцгой нөхцөл байдал” гэж аюулт үзэгдэл, ослоос үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн байгаа орчин, дэд бүтцэд ноцтой хохирол учруулж, хүн-нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг;

4.1.20. “гамшгаас урьдчилан сэргийлэх” гэж аюулт үзэгдэл, ослын хор уршиг, хохирол, сөрөг үр дагавраас зайлсхийх, таслан зогсоох, бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа цогц арга хэмжээг;

4.1.21. “хүмүүнлэгийн тусламж” гэж иргэн, байгууллага, хуулийн этгээдээс гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулж сайн дурын үндсэн дээр өгч байгаа мөнгөн хөрөнгө, техник хэрэгсэл, бараа материал, ажил, үйлчилгээг;

4.1.22. “хорио цээрийн дэглэм” гэж цацраг хими, биологийн осол болон хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, цар тахлаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, таслан зогсоох зорилгоор халдварласан, халдвар тээгч, халдварласан байж болзошгүй сэжиг бүхий болон тэдгээрийн харьцагч, хавьтагч хүн, мал, амьтан, эд материалыг тусгай нөхцөлд тогтоосон хугацаагаар бусдаас тусгаарлах, эмчлэх, сувилах, хяналт-ажиглалтад байлгах, ариутгахыг;

4.1.23. “хязгаарлалтын дэглэм” гэж засаг захиргаа, нутаг дэвсгэр, голомтын бүсэд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг зогсоох, иргэн, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаа болон эрхийг хязгаарлахыг;

4.1.24. “бэлэн байдал” гэж гамшиг, аюулын сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа нэгдмэл удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээг.”

**2/7 дугаар зүйлийн 7.3.5 дахь заалт:**

“7.3.5.хуульд заасан улсын тэмдэгтийн хураамж төлсөн байх.”

3/10 дугаар зүйлийн 10.3.7 дахь заалт:

“10.3.7.салбар дундын төлөвлөгөө, мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах.”

4/10 дугаар зүйлийн 10.4.6-10.4.17 дахь заалт:

“10.4.6.соёл урлаг, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарлах, цуцлах, хориглох;

10.4.7.харилцаа холбоо, эрчим хүч, хүнс хангамж, шатахуун түгээх газар болон стратегийн зориулалттайгаас бусад худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газар, боловсролын байгууллагын үйл ажиллагааг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар түр зогсоох, хилийн боомтыг түр хаах, эсхүл түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах;

10.4.8.голомтын бүсээс хүн, мал, амьтан, эд хөрөнгийг түр нүүлгэн шилжүүлэх, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, түр орон байр, хүнс тэжээлээр хангах арга хэмжээг зохион байгуулах;

10.4.9.нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хүн амын үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангахад чухал үүрэг бүхий хуулийн этгээдэд тусгай дэглэм тогтоож мөрдүүлэх;

10.4.10.төрийн болон төрийн өмчит байгууллагын үүрэг, зориулалт, хөдөлмөрийн нөхцөл, ажлын цагийн хуваарийг тогтоосон хугацаагаар өөрчлөх;

10.4.11.улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллагын хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээг авах;

10.4.12.стратегийн хүнс, бараа, бүтээгдэхүүний хомсдол, үнийн хөөрөгдөл болон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагад чиглэл болгох, хяналт тавих;

10.4.13.олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээн дэх гамшгийн тухай илт худал мэдээллийн тархалтыг



бууруулах, зогсоох арга хэмжээг тухайн нөхцөлийн хэр хэмжээнд тохируулан тодорхой хүрээ, хугацаатайгаар авч хэрэгжүүлэх;

10.4.14.эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангуулах;

10.4.15.гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед улсын хил хамгаалах байгууллага холбогдох байгууллагатай хамтран хилийн боомтод тусгай дэглэм тогтоож, мөрдүүлэх;

10.4.16.химийн хорт болон аюултай бодис, ачаа тээвэрлэлтийг хязгаарлах, шаардлагатай тохиолдолд түр хугацаагаар зогсоох;

10.4.17.зайлшгүй шаардлагатай тохиолдолд иргэн, байгууллага, хуулийн этгээдээс холбогдох мэдээллийг авах бөгөөд тухайн мэдээллийн нууцлалыг хадгалах, түүнчлэн гамшгаас хамгаалахаас бусад зорилгоор урвуулан ашиглахгүй байх.”

5/10 дугаар зүйлийн 10.9-10.11 дэх хэсэг:

“10.9.Энэ хуулийн 10.4-т заасны дагуу гарах аливаа шийдвэр, арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд доор дурдсан шаардлагыг нэг мөр хангана:

10.9.1.хуульд заасан үндэслэл, журмын дагуу гарсан байх;

10.9.2.үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой байх;

10.9.3.энэ хуулийн 10.9.2-т заасан зорилгод хүрэхэд зайлшгүй, тухайн нөхцөлд тохирсон, тодорхой хүрээ, хугацаатай байх;

10.9.4.хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг хөндөөгүй байх.

10.10.Гамшгаас хамгаалах зорилгоор гарах шийдвэр, арга хэмжээ нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тухайн нөхцөлд тохируулан хамгийн бага хязгаарласан байна.

10.11.Монгол Улсын Их Хурал нь энэ хуулийн 10.4-т заасны дагуу Засгийн газраас гарах шийдвэр Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн эсэхэд тогтмол хяналт тавина.”

**6/11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт:**

“11.2.1.энэ хуулийн 11.2-т заасан “бүрэн” гэдгийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг бүхэлд нь, “хэсэгчилсэн” гэдгийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим хэсэг, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийн тодорхой хэсгийг бэлэн байдлын зэрэгт шилжүүлэхийг ойлгоно.”

7/17 дугаар зүйлийн 17.2, 17.3 дахь хэсэг:

“17.2.Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох, ажиллах журмыг Засгийн газар батална.

17.3.Голомтын бүсэд хэрэгжүүлж байгаа арга хэмжээг тухайн шатны онцгой байдлын байгууллага удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавина.”

8/19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг:

“19.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь хүн амыг нүүлгэн шилжүүлэх талбай, байршуулах байр, байгууллага, хуулийн этгээд нь түр цугларах аюулгүйн талбайтай байна.”

9/25¹ дүгээр зүйл:**“25¹ дүгээр зүйл.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүрэн эрх**

25¹.1.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед холбогдох асуудлыг шуурхай хэлэлцэж, Улсын Их Хурал, Засгийн газарт чиглэл, зөвлөмж өгөх.”

10/26 дугаар зүйлийн 26.1.6-26.1.8 дахь заалт:

“26.1.6.гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх шийдвэр гаргах;

26.1.7.Улсын онцгой комиссын саналын дагуу гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тогтоох, холбогдох хөрөнгийг шийдвэрлэх;

26.1.8.Улсын онцгой комиссын саналыг үндэслэн шаардлагатай тохиолдолд бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хуульд заасан нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг түр хориглох.”

11/27¹дүгээр зүйл.

“27¹дүгээр зүйл.Онцгой комиссын бүрэн эрх

27¹.1.Улсын онцгой комисс гамшгаас хамгаалах асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

27¹.1.1.гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах, хяналт тавих;

27¹.1.2.гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед Засгийн газраас тогтоосон чиглэлийн хүрээнд энэ хуулийн 10.4, 10.7-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих;

27¹.1.3.гамшгаас хамгаалах алба, орон нутгийн онцгой комисс, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах асуудлаар хүлээсэн эрх, үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох;

27¹.1.4.гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар тогтоол, албан даалгавар гаргах;

27¹.1.5.гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын талаар болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг Засгийн газарт танилцуулах;

27¹.1.6.шаардлагатай тохиолдолд гамшгаас хамгаалах арга хэмжээг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах шуурхай штабыг, орон нутагт шуурхай бүлгийг байгуулж, ажиллуулах;

27¹.1.7.шаардлагатай тохиолдолд төрийн байгууллага, хуулийн этгээдийн мэдээллийг сонсох.

27¹.2.Орон нутгийн онцгой комисс нь энэ хуулийн 27¹.1.1, 27¹.1.2, 27¹.1.3, 27¹.1.4, 27¹.1.5, 27¹.1.6, 27¹.1.7-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

27¹.3.Онцгой комиссын шийдвэр, тогтоосон хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм, түүнийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг сахин мөрдөхийг тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтан, иргэнээс шаардана.

27¹.4.Шуурхай штаб, шуурхай бүлгийн үйл ажиллагааны зардлыг Засгийн газрын, орон нутагт Засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус санхүүжүүлнэ.



27¹.5.Улсын онцгой комиссын өдөр тутмын үйл ажиллагааг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

27¹.6.Улсын онцгой комисс нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, бэлгэдэл, хэвлэмэл хуудастай байна.”

12/28 дугаар зүйлийн 28.1.11 дэх заалт:

“28.1.11.гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төсвийн төслийг Засгийн газарт оруулж батлуулах.”

13/30 дугаар зүйлийн 30.1.18 дахь заалт:

“30.1.18.улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийг бүрдүүлэх, хадгалах, хуваарилах, хяналт тавих, аюулгүй байдлыг хангах.”

14/30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэг:

“30.4.Онцгой байдлын байгууллагыг төлөөлөх, төсөв, хөрөнгийг захиран зарцуулах шийдвэр гаргах эрхээ харьяа санхүүгийн нэгжийн дарга, эсхүл энэ хуулийн 42.6-д заасан албан тушаалтанд шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.”

15/32 дугаар зүйлийн 32.1.14 дэх заалт:

“32.1.14.онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сум, суурин газарт гамшгаас хамгаалах асуудлыг Засаг даргын тамгын газрын аль нэг албан тушаалтанд хавсран гүйцэтгүүлнэ.”

16/33 дугаар зүйлийн 33.1.14 дэх заалт:

“33.1.14.хариуцсан салбарын хүрээнд холбогдох дүрэм, журам, удирдамж, заавар, стандартыг боловсруулж, батлуулах.”

17/37 дугаар зүйлийн 37.2.8 дахь заалт:

“37.2.8.хорио цээр болон хязгаарлалтын дэглэм тогтоосон үед эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл, иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичигтэй зорчих.”

18/42 дугаар зүйлийн 42.4.1 дэх заалт:

“42.4.1.энэ хуулийн 42.4-т заасан төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйлдвэр, үйлчилгээний байгууллагын дэргэд байгуулсан онцгой байдлын байгууллагын харьяа нэгжийн үйл ажиллагааны бүх зардлыг тухайн байгууллага бүрэн хариуцах.”

19/42 дугаар зүйлийн 42.6-42.9 дэх хэсэг:

“42.6.Онцгой байдлын байгууллага нь тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, хоёр дэд даргатай байна.

42.7.Нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засаг, байгаль, газар зүй, цаг агаарын онцлогийг харгалзан Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулна.

42.8.Онцгой байдлын байгууллагын бүсийн ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

42.9.Гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах чиг үүрэг бүхий салбар, нэгжийн техник, багаж хэрэгслийн төрөл, хангамжийг стандартаар тогтооно.”

20/44 дүгээр зүйлийн 44.1.5 дахь заалт:

“44.1.5.улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах.”

21/45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэг:

“45.5.Төрийн болон албаны нууцад хамаарах бараа, материалыг бүртгэх, хадгалах, хамгаалах асуудал эрхэлж байгаа ажилтан нь энэ хуульд заасан алба хаагчийн нэгэн адил эрх, үүрэг хүлээж эрх зүйн баталгаагаар хангагдана.”

22/46 дугаар зүйлийн 46.6 дахь хэсэг:

“46.6.Онцгой байдлын байгууллагын дүрэмт хувцсыг иргэн, байгууллага, хуулийн этгээд хэрэглэхийг хориглоно.”

23/48 дугаар зүйлийн 48.2, 48.3 дахь хэсэг:

“48.2.Онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэргүйгээр алба хаагчаар энэ хуулийн 44.1-д заасан чиг үүрэгт хамааралгүй ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

48.3.Энэ хуулийн 48.2-т заасан албан тушаалтан гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.”

24/50 дугаар зүйлийн 50.10-50.13 дахь хэсэг:

“50.10.Алслагдсан аймаг, сумын нутаг дэвсгэрт байрлах онцгой байдлын байгууллагын харьяа нэгжид тухайн аймгийн харьяалалгүй алба

хаагчийг томилон ажиллуулбал түүнд албан тушаалын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг улирал тутамд олгоно.

50.11.Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөн олговор олгоно.

50.12.Энэ хуулийн 50.10, 50.11-д заасан нэмэгдэл, нөхөн олговор олгох журмыг Засгийн газар батална.

50.13.Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, уул уурхайн аврах албанд ажилласан хугацааг онцгой байдлын байгууллагад ажилласан хугацаанд оруулан тооцно.”

2 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “уялдуулан зохицуулах,” гэсний дараа “зохион байгуулах,” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “үйлдвэрлэл” гэсний өмнө “уул уурхай,” гэж, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “үйл ажиллагаа нь” гэсний дараа “урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тулгуурлах бөгөөд” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “8.1-д заасан” гэсний дараа “засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж,” гэж, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “Гамшгаас хамгаалах” гэсний дараа “болон гал түймрийн” гэж, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “онцгой байдлын” гэсний дараа “болон төрийн тусгай чиг үүрэг бүхий” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.12 дахь заалтын “гамшгийн” гэсний дараа “судалгаа, шинжилгээ хийх,” гэж, 29.1.17 дахь заалтын “хөгжүүлэх” гэсний дараа “, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх” гэж, 34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь заалтын “хангах” гэсний дараа “, зарлан мэдээлэл дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх” гэж, 34.2.8 дахь заалтын “гамшиг” гэсний дараа “, гамшгийн онцгой нөхцөл байдал” гэж, 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийн “тэргүүн” гэсний дараа “дэд дарга,” гэж, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсгийн “тооцно” гэсний дараа “/дүйцүүлэн тооцох хугацааг 1999 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцно/” гэж, 50.4 дэх хэсгийн “далд уурхай,” гэсний дараа “ой, хээрийн түймэр, халдварт өвчин, цар тахлын голомт,” гэж, 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийн “бол” гэсний дараа “Төрийн албаны тухай хууль,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт:

“4.1.2.“аюулт үзэгдэл” гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх,

гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах зэргийг;”

2/4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт:

“4.1.7.“гамшгаас хамгаалах үйл ажиллагаа” гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхийг;”

3/4 дүгээр зүйлийн 4.1.11, 4.1.12 дахь заалт:

“4.1.11.“голомтын бүс” гэж гамшиг, аюул, аюулт үзэгдэл, ослын улмаас хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоон, эсхүл шууд эрэн хайх, аврах, нүүлгэн шилжүүлэх, хор уршгийг арилгах ажиллагаа явуулж байгаа объект, нутаг дэвсгэрийг;

4.1.12.“нэрвэгдэгсэд” гэж гамшиг, аюулын улмаас амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирсон иргэдийг;”

4/4 дүгээр зүйлийн 4.1.14-4.1.16 дахь заалт:

“4.1.14.“гамшгийн хор уршиг” гэж гамшиг, аюулын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, мал, амьтан хорогдсон, эд хөрөнгө үрэгдсэн, дэд бүтэц эвдэрсэн, хүрээлэн байгаа орчинд нөлөөлсөн зэрэг сөрөг үр дагаврыг;

4.1.15.“гамшгийн хор уршгийг арилгах” гэж энэ хуулийн 4.1.14-т заасан үр дагаврыг зогсоох, бууруулах, хохирол багатай давахад чиглэсэн хойшлуулшгүй арга хэмжээг;

4.1.16.“хойшлуулшгүй сэргээн босгох” гэж гамшиг, аюулын улмаас үүссэн нөхцөлийг хэвийн байдалд оруулахад чиглэсэн шинээр босгох, сэргээн засварлах арга хэмжээг.”

5/6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалт:

“6.1.6.гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээллээр хангах;”

6/7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэг:

“7.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь өмчийн хэлбэрийг үл харгалзан гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийнэ.

7.2.Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ.”

**7/8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг:**

“8.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна.”

8/9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг:

“9.2.“Бүтцийн арга хэмжээ” гэж барилга байгууламж, объект, зам, гүүр, далан болон бусад дэд бүтцийн аюулгүй, гамшигт тэсвэртэй байдлыг хангах арга хэмжээг ойлгоно.”

9/10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг:

“10.1.Гамшгаас хамгаалах бэлэн байдал нь дараах зэрэгтэй байна.”

10/10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг:

“10.4.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед энэ хуулийн 10.3-т зааснаас гадна дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:”

11/10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэг:

“10.7.Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед энэ хуулийн 10.3, 10.4-т заасан арга хэмжээг бүхэлд нь хэрэгжүүлнэ.”

12/11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг:

“11.2.Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт бүрэн, эсхүл хэсэгчилсэн байдлаар, шат дараалан, эсхүл шууд шилжүүлнэ.”

13/11 дүгээр зүйлийн 11.3.1-11.3.4 дэх заалт:

“11.3.1.сум, дүүргийн нутаг дэвсгэрт холбогдох мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тухайн сум, дүүргийн Онцгой комиссын дарга;

11.3.2.хоёр буюу түүнээс дээш сум, дүүрэг, аймгийн нутаг дэвсгэрт холбогдох мэргэжлийн байгууллага болон тухайн сум, дүүргийн Онцгой комиссын даргын саналыг үндэслэн тухайн аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга;

11.3.3.улсын хэмжээнд, эсхүл нийслэл болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт Улсын Онцгой комиссын даргын саналыг үндэслэн Засгийн газар;

11.3.4.шаардлагатай тохиолдолд хариуцсан салбар, байгууллагыг гамшгаас хамгаалах улсын албаны дарга.”

14/11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэг:

“11.5.Энэ хуулийн 13.3.1-д заасан сургалтын үед тухайн шатны Засаг даргын шийдвэрээр өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт түр шилжүүлж болно.”

15/15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг:

“15.1.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал, аюулт үзэгдэл, ослын үеийн үйл ажиллагаа дараах арга хэмжээнээс бүрдэнэ:”

16/17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт:

“17.1.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэр, объектод хор уршгийг арилгах арга хэмжээг шууд удирдан зохион байгуулж байгаа мэргэжлийн байгууллагын удирдлага, эсхүл мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга;”

17/21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг:

“21.3.Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дотоодын болон гадаад улсын, эсхүл олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэдийн хүмүүнлэгийн тусламжийг авч болно.”

18/22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг:

“22.3.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих эрх бүхий Улсын онцгой комиссыг Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга байгуулна.”

19/22 дугаар зүйлийн 22.5, 22.6 дахь хэсэг:

“22.5.Үндэсний болон орон нутгийн зөвлөл нь хөгжлийн бодлого төлөвлөлтөд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг тусгах, бодлогын зөвлөмж, чиглэл гаргах чиг үүрэгтэй, орон тооны бус байна.



22.6.Салбар дундын гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, уялдуулан зохицуулах, мэдээ, мэдээлэл солилцох, хүч хэрэгсэл, нөөцийг оновчтой хуваарилах зорилгоор төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, холбогдох бусад байгууллагыг түшиглэн гамшгаас хамгаалах орон тооны бус Улсын албыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэл, сум, дүүрэгт орон нутгийн албыг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулна.”

20/22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсэг:

“22.9.Үндэсний зөвлөл, Улсын онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар, гамшгаас хамгаалах улсын албаны бүрэлдэхүүн, ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, мэргэжлийн ангийн ажиллах дүрмийг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.”

21/23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг:

“23.2.Үндэсний зөвлөлийг Ерөнхий сайд, орон нутгийн зөвлөлийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тэргүүлнэ.”

22/24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг:

“24.1.Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл нь онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагч, цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа болон цэргийн жинхэнэ алба хаасан иргэн, гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, хуулийн этгээд, эрэлч нохой, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, түүний объект, барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, бараа материал байна.”

23/25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг:

“25.1.Үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулахуйц гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал тохиолдсон үед Монгол Улсын Их Хурал уг асуудлыг дараалал харгалзахгүйгээр нэн яаралтай хэлэлцэж, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг гаргана.”

24/26 дугаар зүйлийн 26.1.1, 26.1.2 дахь заалт:

“26.1.1.Монгол Улсын гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, төсөл, хөтөлбөр, дүрэм, журмыг батлах;

26.1.2.Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг батлах, гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, гамшгийн зэрэглэлийг тогтоох;”

25/26 дугаар зүйлийн 26.1.5 дахь заалт:

“26.1.5.гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал, түүний эсрэг авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний талаар зарлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол, шуурхай, хүртээмжтэй, дэлгэрэнгүй мэдээлэх;”

26/30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг:

“30.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3-т заасан бүрэн эрхээс гадна доор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.”

27/30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалт:

“30.1.2.гамшгаас хамгаалах хүч хэрэгслийг дайчлан гаргах, хуваарилах, оролцуулах;”

28/30 дугаар зүйлийн 30.1.14 дэх заалт:

“30.1.14.онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтцийн нэгж, харьяа салбар, нэгжийн бүтэц, орон тоо, цалингийн санг тогтоох, алба хаагч болон бусад ажилтныг томилох, чөлөөлөх;”

29/31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалт:

“31.1.3.гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах арга хэмжээг санхүүжүүлэх төсвийг хуулийн дагуу батлах.”

30/32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт:

“32.1.3.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, гамшгаас хамгаалах болон орон нутгийн нөөцийг бүрдүүлэх, түүнийг захиран зарцуулах;”

31/34 дүгээр зүйлийн 34.2.10 дахь заалт:

“34.2.10.эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг зөрчсөн, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүйн улмаас учирсан хохирол, хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг хариуцах.”

**32/37 дугаар зүйлийн 37.2.7 дахь заалт:**

“37.2.7.эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг зөрчсөн, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүйн улмаас хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардал, учирсан хохирол, хуурамч дуудлага өгсний улмаас гарсан зардлыг нөхөн төлөх;”

33/42 дугаар зүйлийн 42.3, 42.4 дэх хэсэг:

“42.3.Онцгой байдлын байгууллага нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, штаб, бүсийн төв, аймаг, нийслэл, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар, бүлэг, олон улсын болон агаарын эрэн хайх, аврах баг, эрэлч нохойн алба, шуурхай удирдлага-зарлан мэдээллийн төв, ар тал, тээвэр-ложистик, бүтээн байгуулалт-барилга байгууламж, техник засвар, үйлчилгээ, дүрэмт хувцас, тусгай хэрэгслийн үйлдвэр, эмнэлэг-сувилал, судалгаа шинжилгээ, сургалт, туршилт-үйлдвэрлэл, архив, спорт, соёл урлаг болон бусад нэгжтэй байна.

42.4.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяа нэгжийг газар зүйн онцлог, хүн амын нягтрал, аюулт үзэгдэл, ослын давтамж, хамрах цар хүрээг харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид, үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйлдвэр, үйлчилгээний байгууллагын дэргэд Засгийн газрын шийдвэрээр байгуулна.”

34/46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг:

“46.3.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид цэргийн цол олгох журам болон дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Засгийн газар, хангалтын зааврыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.”

35/51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэг:

“51.2.Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, нийслэл, сум, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна.”

4 дүгээр зүйл.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын “аюулд” гэснийг “ аюулт үзэгдэл, осолд” гэж, 10

дугаар зүйлийн 10.4.4 дэх заалтын “хорио цээрийн” гэснийг “хорио цээр, хязгаарлалтын” гэж, 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсгийн “10-аас” гэснийг “15-аас”, “5-аас” гэснийг “10-аас” гэж, 50 дугаар зүйлийн 50.9 дэх хэсгийн “20” гэснийг “30” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн “асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.3.1 дэх заалтын “нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсгийн “, эсхүл түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.4 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.1.46 дахь заалт:

“5.1.46.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7.3-д заасан тусгай зөвшөөрөл олгох.”

2/21 дүгээр зүйлийн 21.1.36 дахь заалт:

“21.1.36.гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгоход 1 000 000-1 500 000 төгрөг.”



2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “хуулийн” гэсний дараа “4.1.8-д заасан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа,” гэж, 11.5.1 дэх заалтын “арилгах” гэсний дараа “, эрсдэлийг бууруулах” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Онц байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “тохиолдолд” гэсний дараа “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжөөр” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Онц байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “аюулт үзэгдэл, осол” гэснийг “гамшгийн онцгой нөхцөл байдал” гэж, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтын “иргэний хамгаалалтын асуудал эрхэлсэн төв” гэснийг “Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэж, 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нутгийн захиргааны” гэснийг “төрийн болон нутгийн захиргааны, онцгой байдал, дотоодын цэргийн” гэж тус тус өөрчилсүгэй.



3 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН
АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийн “тоног төхөөрөмж,” гэсний дараа “багаж хэрэгсэл, техник,” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалтын “гэнэтийн” гэсний өмнө “гамшгийн онц нөхцөл байдал зарласан, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн” гэж, 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсгийн “хил хамгаалах” гэсний дараа “, онцгой байдлын” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

**ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл.2020 оны 05 дугаар сарын 14-ний өдөр баталсан Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.9, 50.10, 50.11 дэх хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар
хот

“Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрийн өндөр албаны тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл тогтоох тухай” Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”-ийн “ТӨ-VIA”-ийн захиргааны албан тушаалд “Улсын Их Хурлын Тамгын газрын тэргүүн дэд, дэд дарга” гэж нэмсүгэй.

2. “Төрийн өндөр албаны тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл тогтоох тухай” Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”-ийн “ТӨ-V”-ийн “Захиргааны албан тушаал” гэсэн баганын “Тамгын газрын” гэснийг хассугай.

3. Энэ тогтоолыг Монгол Улсын Их Хурлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар
хот

Цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.10, 57.13 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын даргын зөвлөхийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр”-ийг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын Их Хурлын 2020 оны
40 дүгээр тогтоолын хавсралт

ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ИТГЭЛЦҮҮР

Д/д	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн итгэлцүүр
1	Улсын Их Хурлын дарга	3.03
2	Улсын Их Хурлын дэд дарга	2.32
3	Улсын Их Хурлын гишүүн	2.24
4	Улсын Их Хурлын даргын зөвлөх	2.10
	Яамны төрийн нарийн бичгийн даргын албан тушаалын сарын цалингийн хамгийн өндөр шатлал	1.00

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар
хот

“Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

1.“Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын



01-ний өдрийн 18 дугаар тогтоолын хавсралтын “Улсын Их Хурлын Тамгын газар” гэсэн хэсгийн “Тэргүүн түшмэл” гэсэн ангиллын “АА-1” гэсэн зэрэглэлд “Нарийн бичгийн дарга” гэснийг “Газрын дарга, Хүрээлэнгийн захирал” гэж, “АА-2” гэсэн зэрэглэлд “Хэлтэс, албаны дарга” гэснийг “Хэлтсийн дарга” гэж, “Эрхэлсэн түшмэл” гэсэн ангиллын “АА-4” зэрэглэлд “Тасгийн дарга, ахлах зөвлөх” гэснийг “Зөвлөх” гэж, “АА-5” зэрэглэлд “Зөвлөх, ахлах референт” гэснийг “Ахлах референт” гэж, “Ахлах түшмэл” гэсэн ангиллын “АА-7 зэрэглэлд “Ахлах шинжээч” гэснийг “Шинжээч” гэж, “АА-8 зэрэглэлд “Шинжээч” гэснийг “Нарийн бичгийн дарга, Даргын туслах” гэж тус тус өөрчилсүгэй.

2. “Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 18 дугаар тогтоолын хавсралтын “Улсын Их Хурлын Тамгын газар” гэсэн хэсгийн “Тэргүүн түшмэл” гэсэн ангиллын “АА-3” гэсэн зэрэглэлд “Албаны дарга, Ахлах зөвлөх” гэж хамааруулан нэмсүгэй.

3. Энэ тогтоолыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар
хот

Цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.13 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр”-ийг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын Их Хурлын 2020 оны
42 дугаар тогтоолын хавсралт

ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ИТГЭЛЦҮҮР

Д/д	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн итгэлцүүр
1	Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга	2.7
2	Тамгын газрын тэргүүн дэд дарга	2.4
3	Тамгын газрын дэд дарга	2.1
4	Газрын дарга, Хүрээлэнгийн захирал	2.0
5	Хэлтсийн дарга	1.95
6	Албаны дарга, Ахлах зөвлөх	1.90
7	Зөвлөх	1.85
8	Ахлах референт	1.80
9	Референт	1.75
10	Шинжээч	1.60
11	Нарийн бичгийн дарга, Даргын туслах	1.55
12	Ахлах мэргэжилтэн	1.50
13	Мэргэжилтэн	1.45
14	Ахлах зохион байгуулагч	1.40
	Яамны газрын даргын албан тушаалын сарын цалингийн хамгийн өндөр шатлал	1.00

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар
хот

“Зарим албан тушаалтны цалингийн хэмжээг тогтоох тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Зарим албан тушаалтны цалингийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 57 дугаар тогтоолын хүснэгтийн “Адилтгах албан тушаал” гэсэн баганын “Улсын Их Хурлын Тамгын газрын нарийн бичгийн дарга” гэснийг “Улсын Их Хурлын Тамгын газрын Газрын дарга” гэж өөрчилсүгэй.



2. “Зарим албан тушаалтны цалингийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 57 дугаар тогтоолын хүснэгтийн “Адилтгах албан тушаал” гэсэн баганын 2 дахь мөрийг “Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны зөвлөх”-д хамаарах “Улсын Их Хурлын Тамгын газрын зөвлөх” гэсэн 2 дахь мөр, “Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны ахлах референт”-д хамаарах “Улсын Их Хурлын Тамгын газрын ахлах референт” гэсэн 3 дахь мөр болгон тус тус өөрчилсүгэй.

3.Энэ тогтоолыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар
хот

“Цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр батлах тухай” тогтоолд нэмэлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.9, 57.10, 57.13 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12 дахь хэсэг, Төрийн аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэг, Прокурорын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 63 дугаар тогтоолын 1 дэх заалтын “Үндсэн хуулийн цэцийн” гэсний өмнө “Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Улсын Их Хурлын гишүүн,” гэж, мөн заалтын “Төрийн аудитын” гэсний өмнө “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын даргын зөвлөх, Улсын Их Хурлын Тамгын газрын тэргүүн дэд, дэд дарга,” гэж тус тус нэмсүгэй.

2.Энэ тогтоолыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар
хот

Түр хороо байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаар 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Түр хорооны дарга:

Т.Аюурсайхан

-Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга

Түр хорооны гишүүд:

Х.Болорчулуун

-Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга

Д.Оюунхорол

-Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга

М.Оюунчимэг

-Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга

С.Бямбацогт

-Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга

Б.Чойжилсүрэн

-Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга



Х.Нямбаатар	-Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга
Ж.Ганбаатар	-Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга
О.Баасанхүү	-Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын зөвлөлийн төлөөлөл
Л.Болд	-Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Шинэ намын зөвлөлийн дарга

2.Энэ тогтоолыг Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ЗЭЭЛИЙН ДУГААР 6594-МН

Санхүүжилтийн хэлэлцээр

(Монгол Улсад COVID-19-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл)

МОНГОЛ УЛС

болон

ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ

хоорондын хэлэлцээр

ЗЭЭЛИЙН ДУГААР 6594-МН

САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү ХЭЛЭЛЦЭЭР нь МОНГОЛ УЛС (“Хүлээн авагч”) болон ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ (“Ассоциаци”) нар гарын үсэг зурсан өдрөөр баталгаажна.



Хүлээн авагч нь Банкинд энэхүү Хэлэлцээр (“Төсөл”)-ийн Хуваарь 1-т тусгасан төслийн санхүүжилтийн дэмжлэг авах хүсэлт гаргасан бөгөөд Банкны зүгээс Хүлээн авагч болон тус Банк хооронд энэхүү хэлэлцээртэй зэрэг байгуулсан зээлийн хэлэлцээр (“Зээлийн хэлэлцээр”)-ийн дагуу арван гурван сая найман зуун мянган ам.доллар (13,800,000 ам.доллар)-тай тэнцэх зээл олгохоор зөвшөөрсөн ТУЛ,

ТҮҮНД ҮНДЭСЛЭН, Хүлээн авагч болон Ассоциаци дараах зүйлсийг хүлээн зөвшөөрч байна. Үүнд:

I БҮЛЭГ — ЕРӨНХИЙ НӨХЦӨЛҮҮД; НЭР ТОМЬЁОНУУД

- 1.01. Ерөнхий нөхцөлүүд нь (энэхүү Хэлэлцээрийн хавсралтад тусгасан) энэхүү Хэлэлцээрт хүчин төгөлдөр үйлчлэх төдийгүй энэхүү Хэлэлцээрийн салшгүй нэг хэсэг мөн болно.
- 1.02. Хэлэлцээрийн агуулгад өөрөөр заагаагүй бол энэхүү Хэлэлцээрт том үсгээр тэмдэглэсэн нэр томьёонууд нь Ерөнхий нөхцөлүүд, Зээлийн хэлэлцээр, эсвэл энэхүү Хэлэлцээрт (Оршил ба хавсралт хэсгийг оролцуулаад) тайлбарласан утгыг илэрхийлнэ.

II БҮЛЭГ — САНХҮҮЖИЛТ

- 2.01. Ассоциаци нь энэхүү Төслийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Ерөнхий нөхцөлүүдийн дагуу есөн сая зургаан зуун мянган ЗТЭ (ЗТЭ 9,600,000¹) (өөрөөр “Зээл”, “Санхүүжилт” гэх)-тэй тэнцэх хэмжээний хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг Хүлээн авагчид олгохыг хүлээн зөвшөөрч байна.
- 2.02. Хүлээн авагч нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын III Хэсэгт заасны дагуу санхүүжилтийн хөрөнгийг зарцуулж болно.
- 2.03. Санхүүжилтийн ашиглагдаагүй үлдэгдэлд тооцогдох хөрөнгийг баталгаажуулсны амлалтын хураамжийн дээд хэмжээ жилийн нэг хувийн хагас (1%-ийн 1/2) байна.
- 2.04. Зээлийн ашигласан үлдэгдэлд тооцогдох үйлчилгээний хураамж жилийн нэг хувийн дөрөвний гурав (1%-ийн 3/4) байна.
- 2.05. Зээлийн ашигласан үлдэгдэлд тооцогдох зээлийн хүү жилийн нэг зууны хорин таван хувь (1.25%) байна.
- 2.06. Төлбөр хийх өдөр нь жил бүрийн 4 дүгээр сарын 15 болон 10 дугаар сарын 15-ны өдөр байна.
- 2.07. Үндсэн зээлийг энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 3-т заасан эргэн төлөгдөх хуваарийн дагуу эргэн төлнө.
- 2.08. Төлбөр гүйцэтгэх мөнгөн тэмдэгт америк доллар байна.

¹ 13.1 сая ам.доллартай тэнцэх ЗТЭ-ийн дүнг хэлэлцээр хийх өдөр оруулна.



III БҮЛЭГ — ТӨСӨЛ

3.01. Хүлээн авагч нь Төслийн болоод олон шатлалт хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг хангах үүргийг хүлээнэ. Үүнтэй холбогдуулан Хүлээн авагч нь Ерөнхий нөхцөлүүдийн V Бүлэг болон энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-т тусгасан заалтуудын дагуу төслийг хэрэгжүүлнэ.

IV БҮЛЭГ — ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ; ЦУЦЛАХ

4.01. Зээлийн хэлэлцээрийг үйлдэж, хүргүүлсэн байхын зэрэгцээ түүний хүчин төгөлдөр болохтой болоод тус хэлэлцээрийн хүрээнд хөрөнгө зарцуулах эрх Хүлээн авагчид үүсэхтэй холбоотойгоор заасан урьдчилсан бүх нөхцөл (энэхүү Хэлэлцээрийн хүчин төгөлдөр болохтой холбоотой нөхцөлүүд хамаарахгүй) хангагдсан байх нь энэхүү Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгоход тавигдах нэмэлт нөхцөл болно.

4.02. Хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь Гарын үсэг зурсан өдрөөс нэг зуун наян (180) хоног байна.

4.03. Ерөнхий нөхцөлүүдийн 10.05 (b) Хэсэгт тусгасны дагуу Хүлээн авагчийн Хэлэлцээрийн үүрэг хариуцлага (төлбөрийн үүрэг, хариуцлагаас бусад) гарын үсэг зурсан өдрөөс хорин (20) жилийн дараа дуусгавар болно.

V БҮЛЭГ — ТӨЛӨӨЛӨГЧИД; ХОЛБОГДОХ ХАЯГУУД

5.01. Хүлээн авагчийг төлөөлөх этгээд нь тухайн үеийн Сангийн сайд байна.

5.02. Ерөнхий нөхцөлүүдийн 11.01-р Хэсэгт заасны дагуу:

(a) Хүлээн авагчийн хаяг нь:

Сангийн яам

Засгийн газрын II байр

С.Данзангийн гудамж 5/1 Д

Улаанбаатар 15160

Монгол Улс

мөн

(b) Хүлээн авагчийн цахим хаяг нь:

Факс:

976-11-320247 тус тус болно.

5.03. Ерөнхий нөхцөлүүдийн 11.01-р Хэсэгт заасны дагуу: (a) Ассоциацийн хаяг нь:

Олон улсын хөгжлийн ассоциаци

1818 Н гудамж, N.W.

Вашингтон хот. 20433
АНУ; мөн
(b) Ассоциацийн цахим хаяг нь:
Телекс: _____ Факс: _____
248423 (МСI) 1-202-477-6391

Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдөр **ХАРИЛЦАН ТОХИРОЛЦОВ.**

Монгол Улсыг төлөөлж

Гарын үсэг зурсан

Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____

ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ-ийг төлөөлж

Гарын үсэг зурсан

Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____

ХУВААРЬ 1

Төслийн тодорхойлолт

Энэхүү төсөл нь Монгол Улсад Коронавируст халдварын тархалтаас сэргийлж, хариу ажиллагаа явуулах чадавхыг бэхжүүлэх, нийгмийн эрүүл мэндийн бэлэн байдлыг хангах үндэсний тогтолцоог сайжруулах зорилготой юм.

Төсөл нь Олон шатлалт хөтөлбөрийн нэг үе шат байх ба Зээлийн хэлэлцээрт тусгасан хэсгүүдээс бүрдэнэ.



ХУВААРЬ 2

Төслийн гүйцэтгэл

I Хэсэг. Хэрэгжилттэй холбоотой заалтууд

- A. Зээлийн хэлэлцээрийн Хавсралт 2-ын I Хэсэг (Хэрэгжүүлэлтийн зохицуулалт) болон II Хэсэг (Төслийн хяналт-шинжилгээ, тайлагнал ба үнэлгээ) нь энэхүү А Хэсэгт хамаарагдах бөгөөд энэхүү Хэлэлцээрт давхар хүчин төгөлдөр үйлчлэхээс гадна Хүлээн авагч нь тэдгээр заалтуудыг энэхүү Хэлэлцээрт давхар заасан гэж ойлгон хүлээн зөвшөөрч байгаа болно. Үүнд үл хамаарах зүйлс нь:
- (a) “Зээлдэгч” гэх нэр томъёог “Хүлээн авагч” гэж ойлгох;
(b) “Банк” гэх нэр томъёог “Ассоциаци” гэж ойлгох;
- B. Зээлийн хэлэлцээрийн Хуваарь 2-ын I болон II Хэсгийг энэхүү Хэлэлцээрт тусгаж оруулсан нь Зээлийн хэлэлцээр энэхүү Хэлэлцээрээс өмнө дуусгавар болсон ч гэсэн энэхүү Хэлэлцээрийн хүчин төгөлдөр үйлчлэлд нөлөөлөхгүй бөгөөд энэхүү Хэлэлцээрийн Хэсэг I.A-д дээр тусгасан Зээлийн хэлэлцээрийн холбогдох заалтууд нь Хүлээн авагч болон Ассоциацийн хооронд Зээлийн хэлэлцээр дуусгавар болсны дараа ч гэсэн түүнээс үл хамааран хүчин төгөлдөр үйлчилнэ.

II Хэсэг. Санхүүжилтийн хөрөнгийн зарцуулалт

A. Ерөнхий

Ерөнхий нөхцөлүүдийн II Зүйл болон Ассоциациас Хүлээн авагчид хүргүүлэх Зарцуулалтын болон санхүүгийн мэдээллийн албан захидлын дагуу Хүлээн авагч нь доорх хүснэгт дэх ангилал тус бүрд хуваарилагдсан зээлийн хэмжээ болон хамаарах санхүүжилтийн хувь хэмжээнд нийцүүлэн санхүүжилтийг татан авч Зөвшөөрөгдсөн зардлыг санхүүжүүлж болно:

Ангилал	Зээлийн хөрөнгийн хуваарилалт (ЗТЭ-ээр)	Зардлын санхүүжилтийн хувь хэмжээ (Татвар тооцсон)
(1) Төслийн 1, 2 болон 3-р хэсэгт хамаарах бараа, ажил, зөвлөхийн бус үйлчилгээ, үйл ажиллагааны зардал болон сургалт	9,600,000	100%
(2) Төслийн 4-р хэсэгт хамаарах онцгой байдлын зардал	0	100%
НИЙТ ДҮН	9,600,000	

Б. Хөрөнгө зарцуулах нөхцөлүүд; Хугацаа

1. Хэсэг А-д заасан заалтуудаас үл хамаарч дараах төлбөрүүдэд зарцуулалт хийхгүй:
 - (a) Энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс өмнө хийсэн төлбөр. Үүнд Ангилал (1)-т хамаарах Зөвшөөрөгдсөн зардлыг санхүүжүүлэхээр 2020 оны 1-р сарын 1-ний өдөр болон түүнээс хойш хийсэн төлбөрүүд хамаарахгүй байж болох авч тэдгээрийн нийлбэр дүн нь 1,500,000 ЗТЭ-ээс хэтэрч үл болно; эсхүл
 - (b) Ангилал (2)-т хамаарах Онцгой байдлын зардал. Гэвч Хүлээн авагч нь холбогдох зардалтай холбоотой дараах бүхий л нөхцөлүүдийг хангасан болохыг Ассоциаци хүлээн зөвшөөрч, түүнд мэдэгдсэн бол тухайн зардлыг санхүүжүүлж болно. Үүнд:
 - (i) Хүлээн авагч нь Зөвшөөрөгдөх хямрал эсхүл онц байдал үүссэн болохыг тогтоож, Ассоциацид тухайн хямрал, онц байдалд хариу ажиллагаа явуулах зорилгоор Онцгой байдлын хариу ажиллагааны хэсэгт санал болгож буй үйл ажиллагааг оруулах хүсэлт ирүүлж, улмаар Ассоциаци тийнхүү дүгнэж, тухайн хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэснээ Хүлээн авагчид мэдэгдсэн;
 - (ii) Хүлээн авагч нь тухайн үйл ажиллагаанд шаардлагатай аливаа хамгааллын хөтөлбөр боловсруулж, нийтэд ил болгосон бөгөөд Зээлийн хэлэлцээрийн Хуваарь 2-ын Хэсэг I.Г болон I.Д-д тус тус заасан заалтууд (мөн энэхүү Хавсралтын Хэсэг I-т заасан холбогдох заалтуудын хамт)-ын дагуу тухайн хөтөлбөрүүдийн хүрээнд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлсэн;
 - (iii) Зээлийн хэлэлцээрийн Хуваарь 2-ын Хэсэг I.Д-д заасан заалтууд (мөн энэхүү Хавсралтын Хэсэг I-т заасан холбогдох заалтуудын хамт)-ын дагуу Онцгой байдлын хариу ажиллагааг уялдуулан зохицуулах болон хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллагуудад тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүн хүч болон бусад хүч нөөцөөр хангасан байх; мөн
 - (iv) Хүлээн авагч нь Ассоциацийн шаардлагад хэлбэр, агуулгын хувьд бүрэн нийцэх Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө [ERM]-г нэвтрүүлэх бөгөөд тус төлөвлөгөөний заалтууд эсхүл Зээлийн хэлэлцээрийн Хуваарь 2-ын Хэсэг I.Д-д заасан заалтууд (мөн энэхүү Хавсралтын Хэсэг I-т заасан холбогдох заалтуудын хамт)-ын дагуу шинэчилсэн заалтууд нь Онцгой байдлын хариу ажиллагааны хэсгийг хамруулан хэрэгжүүлэхэд оновчтой хэвээр байна.



2. Төсөл хаах өдөр нь 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдөр байна.

ХУВААРЬ 3

Эргэн төлөлтийн хуваарь

Төлбөр хийх огноо	Эргэн төлөх зээлийн үндсэн хэмжээ (хувиар илэрхийлэв)*
Жил бүрийн 4 дүгээр сарын 15 ба 10 дугаар сарын 15-ны өдөр	
2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2044 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг оролцуулаад	1.65%
2045 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2049 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг оролцуулаад	3.40%

* Ерөнхий нөхцөлүүдийн 3.05 (б) хэсэгт заасны дагуу Ассоциациас өөрөөр заагаагүй бол дээрх хувь хэмжээ нь эргэн төлөгдөх үндсэн зээлийн хувь хэмжээг илэрхийлнэ.

ХАВСРАЛТ

Нэр томьёо

1. “Ангилал” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ийн II.A Хэсэгт буй хүснэгтэд заасан ангиллыг хэлнэ.
2. “Ерөнхий нөхцөлүүд” гэж 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан “Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн Ерөнхий нөхцөлүүд”-ийг хэлнэ.
3. “Зээлийн хэлэлцээр” гэж Хүлээн авагч болон Банкны хооронд байгуулсан зээлийн хэлэлцээр, түүнд орох нэмэлт, өөрчлөлтийн хамт хэлнэ. “Зээлийн хэлэлцээр”-т түүнд тусгасан аливаа хавсралт, хуваарь болон гэрээний нэмэлтийг хамруулан хэрэглэнэ.
4. “Үйл ажиллагааны зардал” гэж түрээс, мөн/эсхүл тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тогтмол засвар, үйлчилгээ, ажлын байр ба офисын талбай, түлш, бичиг хэрэг, халаалт, цахилгаан болон харилцаа холбооны зардал (шуудан, утас болон интернетийн гэх зэрэг), тээвэр, орчуулга, хувилж, олшруулах зардал, банкны шимтгэл, хэвлэл, сурталчилгааны зардал, даатгал, Төсөлтэй холбоотой уулзалт, томилгоо, аяллын зардал, гэрээт туслах ажилтны цалин болон Төсөлтэй холбоотой бусад захиргааны зардал гэх зэрэг Төслийн үйл ажиллагааг уялдуулан хэрэгжүүлэх, хяналт тавихад шаардлагатай бараа, зөвлөхийн бус үйлчилгээний зохих зардлыг хэлнэ. Гэхдээ үүнд



Хүлээн авагчийн төрийн албан хаагчдын цалин, урамшуулал болон түүнтэй адилтгах аливаа төлбөр хамаарахгүй болно.

5. “Гарын үсэг зурсан өдөр” гэж энэхүү Хэлэлцээрт Ассоциаци болон Хүлээн авагч тал харилцан гарын үсэг зурсан хоёр өдрийн сүүлийнхийг нь хэлэх бөгөөд энэхүү тодорхойлолт нь Ерөнхий нөхцөлүүдэд тусгагдсан “Санхүүжилтийн хэлэлцээрийн огноо” гэсэн нэр томьёонд мөн хамаарна.

ЗЭЭЛИЙН ДУГААР 9082-MN

Зээлийн хэлэлцээр

(Монгол Улсад COVID-19-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл)

МОНГОЛ УЛС

болон

ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК

хоорондын

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү Хэлэлцээрийг МОНГОЛ УЛС (“Зээлдэгч”) болон ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК (“Банк”) нар гарын үсэг зурсан өдрөөр баталгаажна.

Улмаар Зээлдэгч энэхүү хэлэлцээрийн Хуваарь 1-т заасан төслийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг Ассоциациаас хүссэн (“Төсөл”) бөгөөд Ассоциаци нь есөн сая зургаан зуун мянган Зээлжих тусгай эрхтэй (9,600,000 ЗТЭ) тэнцэх үнийн дүн бүхий санхүүжилтийг Зээлдэгч ба Ассоциацийн хооронд мөн өдөр байгуулсан санхүүжилтийн хэлэлцээрийн (“Санхүүжилтийн хэлэлцээр”) дагуу олгохыг зөвшөөрсөн;

Иймд, Зээлдэгч болон Банк дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов.
Үүнд:

I БҮЛЭГ — ЕРӨНХИЙ НӨХЦӨЛҮҮД; НЭР ТОМЬЁОНУУД

- 1.01. Ерөнхий нөхцөлүүд нь (энэхүү Хэлэлцээрийн хавсралтад заагдсан) энэхүү Хэлэлцээрт хүчин төгөлдөр үйлчлэх төдийгүй түүний салшгүй хэсэг байна.



- 1.02. Хэлэлцээрийн агуулгад өөрөөр заагаагүй бол Хэлэлцээрт том үсгээр тэмдэглэсэн нэр томъёонууд нь Ерөнхий нөхцөлүүд, эсвэл энэхүү Хэлэлцээр (мөн түүний Удиртгал болон Хавсралтад)-нд заасан утгыг илэрхийлнэ.

II БҮЛЭГ — ЗЭЭЛ

- 2.01. Банк нь Төслийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс Валют хөрвүүлэх хэрэгслийн дагуу өөр валютад хөрвүүлэх боломжтой арван гурван сая найман зуун мянган (\$13,800,000) америк доллар (“Зээл”)-ын үнийн дүн бүхий зээлийг Зээлдэгчид олгохыг зөвшөөрсөн.
- 2.02. Зээлдэгч нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын III дахь хэсэгт заасны дагуу Зээлийн хөрөнгийг зарцуулах боломжтой.
- 2.03. Урьдчилсан хураамж нь Зээлийн үнийн дүнгийн нэг хувийн дөрөвний нэг (0.25%) байна.
- 2.04. Зээлийн ашиглагдаагүй үлдэгдэлд тооцох хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийн дээд хэмжээ жилд нэг хувийн дөрөвний нэг (0.25%) байна. Ингэхдээ хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж тооцогдож эхэлсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаа дуусах өдөр хүртэлх хуримтлагдах хувь нь тэг хувь (0%) байна.
- 2.05. Зээлийн хүү Ерөнхий нөхцөлүүдийн 3.02(е) хэсэгт заасны дагуу жишиг хувь дээр хувьсах хүүгийн хувь хэмжээг нэмсэнтэй тэнцэнэ.
- 2.06. Төлбөр хийх өдөр нь жил бүрийн 4 дүгээр сарын 15 болон аравдугаар сарын 15-ны өдөр байна.
- 2.07. Үндсэн зээлийг энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 3-т заасан эргэн төлөгдөх хуваарийн дагуу эргэн төлнө.

III БҮЛЭГ — ТӨСӨЛ

- 3.01. Зээлдэгч нь Төслийн болон Олон шатлалт хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг хангах үүргийг хүлээнэ. Үүнтэй холбогдуулан Зээлдэгч нь Ерөнхий нөхцөлийн V Бүлэг болон энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-т тусгасан заалтуудад нийцүүлэн төслийг хэрэгжүүлнэ.

IV БҮЛЭГ — ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ; ЦУЦЛАХ

- 4.01. Санхүүжилтийн хэлэлцээрийг байгуулж, энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болгох бүх нөхцөлийг хангах буюу Зээлдэгчийн тус



Хэлэлцээрийн дагуу хөрөнгө татаж авах (энэхүү Хэлэлцээрийн хүчин төгөлдөр болох нөхцөлөөс бусад) боломжийг бүрдүүлснийг Хүчин төгөлдөр болгох нэмэлт нөхцөл бүрдсэн гэж үзнэ.

4.02. Хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь Гарын үсэг зурсан өдрөөс нэг зуун наян (180) хоног байна.

4.03. Ерөнхий нөхцөлүүдийн 9.05 (b) Хэсэгт тусгасны дагуу Зээлдэгчийн энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хүлээх үүрэг хариуцлага (төлбөрийн үүрэг, хариуцлагаас бусад) гарын үсэг зурсан өдрөөс хорин (20) жилийн дараа дуусгавар болно.

V БҮЛЭГ — ТӨЛӨӨЛӨГЧИД; ХОЛБОГДОХ ХАЯГУУД

5.01. Зээлдэгчийн төлөөлөл нь тухайн үеийн санхүүгийн асуудал эрхэлсэн Сайд байна.

5.02. Ерөнхий нөхцөлүүдийн 10.01 Хэсэгт заасны дагуу:

(a) Зээлдэгчийн хаяг:

Сангийн яам
Засгийн газрын II дугаар байр
С. Данзангийн гудамж 5/1 Д
Улаанбаатар 15160
Монгол Улс; ба

(b) Зээлдэгчийн цахим хаяг:

Факс:
976-11-320247

5.03. Ерөнхий нөхцөлүүдийн 10.01 Хэсэгт заасны дагуу:

(a) Банкны хаяг:

Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк
1818 H Street, N.W.
Washington, D.C. 20433
United States of America; ба

(b) Банкны цахим хаяг:

Телекс:	Факс:	[И-мэйл:]
248423(MCI) or 64145(MCI)	1-202-477-6391	_____



Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөр ХАРИЛЦАН ТОХИРОЛЦОВ.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

Гарын үсэг зурсан

Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____

ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНКЫГ ТӨЛӨӨЛЖ

Гарын үсэг зурсан

Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____

ХУВААРЬ 1

Төслийн танилцуулга

Төслийн зорилго нь Монгол Улсын Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлж, тус улсын нийгмийн эрүүл мэндийн тогтолцооны бэлэн байдлыг сайжруулах юм.

Төсөл нь Олон шатлалт хөтөлбөрийн нэг үе шатыг төлөөлөх бөгөөд дараах хэсгүүдээс бүрдэнэ:

1-р хэсэг: Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах

1.1. Эрсдэлийн үеийн харилцаа холбоо, олон нийтийн оролцоо

Дараах арга замуудаар дамжуулан харилцаа холбоо, зан төлөвийн өөрчлөлтийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх: (а) Коронавируст халдварын эсрэг арга хэмжээний талаарх мессэж, материалуудыг боловсруулж, турших; мөн (б) үндэсний түвшинээс аймаг, сумын түвшин рүү, төр ба хувийн хэвшил хооронд мэдээллийг түгээх дэд бүтцийг сайжруулах.

1.2. Хариу арга хэмжээнд үзүүлэх дэмжлэг

Үүнд дараах дэмжлэгийг үзүүлнэ: (a) нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ, онцгой тохиолдлуудын удирдлага; (b) тохиолдлын удирдлагын тогтолцоог үндэсний болон орон нутгийн түвшинд ашиглах; (c) эрүүл мэндийн аюулгүй байдлын тогтолцооны гүйцэтгэлийг хянах хяналт-шинжилгээ үнэлгээний системийг боловсруулах; (d) нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн эрсдэлийн удирдлага тал дээр байгууллага хоорондын уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулах; (e) гэнэтийн ослын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тогтолцооны бэлэн байдлыг сайжруулах; мөн (f) эрсдэлийн стратегид үнэлгээг хийх, эрүүл мэндийн эрсдэл ба нөөцийн зураглал гаргах.

1.3. Хүний нөөцийн хөгжил

Үүнд дараах дэмжлэгийн үзүүлнэ: (a) яаралтай тусламжийн эмч, сувилагч, эрчимт эмчилгээний ажилтнуудад сургалт явуулах; (b) Коронавируст халдварыг оношлох чадавхыг үндэсний болон орон нутгийн төвшинд бэхжүүлэх; (c) гамшгийн голомтод ажиллаж байгаа хүмүүст сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх; (d) Коронавируст халдварын сэжигтэй тохиолдлуудын ангилал, эмчилгээ, удирдлага болон мөшгөлтийн талаарх удирдамжийг боловсруулах, түгээх; ба (e) Коронавируст халдварыг илрүүлсэн, эмчилсэн тухай халдвар судлал ба клиникийн судалгаа хийх.

1.4. “Нэг эрүүл мэнд” үзэл санааг хэрэгжүүлэхэд таатай орчныг бүрдүүлэх

Үүнд дараахыг дэмжинэ: (a) салбар хоорондын харилцаа холбоо, уялдаа зохицуулалт, хамтын ажиллагааны хэрэгслүүдийг сайжруулах; (b) нийгмийн эрүүл мэндийн хуулийн мөрдөлтийг сайжруулах; (c) [байгууллага хоорондын] ажиглалт, эрсдэлийн үнэлгээг хийх; (d) нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн бэлэн байдлыг сайжруулах, үүнд эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг нэмэгдүүлэх; мөн (e) эрт сэрэмжлүүлэх системийг ажиллуулж, өвчний дэгдэлтийг хянахын тулд өгөгдөл хуваалцах нэгдсэн платформыг боловсруулах.

2-р хэсэг: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэх

2.1. Эмнэлгийн лабораторийн багаж тоног төхөөрөмж, урвалж бодисыг хангаж өгөх

Үүнд дараах дэмжлэгийг үзүүлнэ: (a) эрүүл мэндийн байгууллагуудын Коронавируст халдварыг оношлох, эмчлэх чадавхыг



сайжруулах; мөн (b) эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага, техникчдэд сургалт явуулах.

2.2. Эм, эмнэлгийн хэрэгслээр хангах

Үүнд: (a) эмнэлгийн онцгой арга хэмжээ, халдварын хяналт, сэргийлэлтийг хангах эм, хэрэгсэл, мөн (b) хавсарсан эмгэг, хүндрэлтэй өвчтөнүүдэд зориулсан эмийг хангах.

3-р хэсэг: Төслийн удирдлага, хяналт-шинжилгээ, үнэлгээ

Үүнд: (a) клиникийн болон нийгмийн эрүүл мэндийн судалгааны чадавхыг бэхжүүлэх, суралцах; мөн (b) төслийн хэрэгжилтэд техникийн болон үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэн, заавар чиглүүлэг, зохицуулалтаар хангахын зэрэгцээ: төлөвлөлт ба хэрэгжилт, худалдан авалт, санхүүгийн удирдлага, байгаль орчин ба нийгмийн удирдлага, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хариуцна.

4-р хэсэг: Онцгой байдлын хариу арга хэмжээ

Онцгой байдал эсхүл Хямралын үед нэн даруй хариу арга хэмжээг хэрэгцээтэй түвшинд нь авах.

ХУВААРЬ 2

Төслийн гүйцэтгэл

I хэсэг. Хэрэгжилтийн зохион байгуулалт

A. Институцийн зохион байгуулалт

1. Зээлдэгч нь Төсөл хэрэгжих хугацааны туршид төсөл хэрэгжүүлэх бүтцийг үндэсний болон орон нутгийн түвшинд ажиллуулах ба Төсөл хэрэгжүүлэх зааврын дагуу Банкны шаардлагад нийцсэн бүрэлдэхүүн, чиг үүрэг, орон тоо, нөөц бололцоогоор хангана.
2. Зээлдэгч нь дараах үүргийг хүлээнэ:
 - (a) Эрүүл мэндийн сайдаар ахлуулж, ЭМЯ, СЯ, болон ХХААХҮЯ-ны төлөөлөгчдөөс бүрдсэн, Төслийн хэрэгжилтийг удирдан чиглүүлэх чиг үүрэг бүхий Төслийн удирдах хороог ажиллуулах;
 - (b) ЭМЯ-ны дор Төсөл хэрэгжүүлэх нэгжийг ажиллуулах. Тус нэгж нь төслийн өдөр тутмын хэрэгжилтийг хариуцан ба дараах чиг үүргийг хүлээнэ (i) жилийн төлөвлөгөө,



төсөв бэлтгэх, (ii) худалдан авах ажиллагаа, санхүүгийн удирдлага, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн удирдлага, ба (iii) Төслийн хяналт-шинжилгээ үнэлгээг хариуцна.

Б. Төсөл хэрэгжүүлэх гарын авлага

1. Зээлдэгч нь Төсөл хэрэгжүүлэх гарын авлагыг энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос нэг сараас (1) хойшгүй хугацаанд боловсруулан баталж, түүнээс хойш төслийг Төсөл хэрэгжүүлэх гарын авлагад нийцүүлэн хэрэгжүүлэхэд анхаарч (Төсөл хэрэгжүүлэх гарын авлага болон энэхүү Хэлэлцээрийн зохицуулалт хооронд аливаа зөрчил гарах тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн заалтууд давуу үйлчилнэ), Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл аваагүй бол Төсөл хэрэгжүүлэх гарын авлагын аль нэг заалтыг өөрчлөх, хүчингүй болгох эрхгүй.

В. Жилийн ажлын төлөвлөгөө, төсөв

1. Зээлдэгч нь бүх зарцуулалтын санхүүжилтийн эх үүсвэрийг тусгасан, энэхүү Хуваарийн Г хэсэгт заасан нөхцөлүүдийн дагуу авсан болон авах гэж буй байгаль орчин, нийгмийн нөлөөллийн удирдлагын бүх арга хэмжээг оролцуулсан, дараагийн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бүхий л үйл ажиллагаа, зарцуулалтыг багтаасан Жилийн ажлын нэгдсэн төлөвлөгөө, төсвийг (ЖАНТТ) төсөл хэрэгжилтийн үеэр санхүүгийн жил тус бүрийн 12 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө боловсруулан бэлтгэж, ЭМЯ-аар дамжуулан Банкнаас зөвшөөрөл авахаар хүргүүлнэ.
2. Зээлдэгч нь төслийг тухайн санхүүгийн жилд Банкнаас баталсан ЖАНТТ-ийн дагуу хэрэгжүүлэх үүрэгтэй ба батлагдсан ЖАНТТ болон энэхүү Хэлэлцээрийн заалтууд хооронд зөрчил гарах тохиолдолд Хэлэлцээрийн заалтууд давуу үйлчлэх болно.
3. Зээлдэгч нь Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр ЖАНТТ-д ямарваа нэгэн өөрчлөлт оруулахгүй бөгөөд оруулахыг зөвшөөрөхгүй.

Г. Байгаль орчин, нийгмийн хамгааллын журам

1. Зээлдэгч нь төслийг Банкны шаардлага хангахуйц Байгаль орчин, нийгмийн хамгааллын шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэхийг баталгаажуулна.



2. Дээрх 1 дэх хэсэгт зааснаас гадна, Зээлдэгч нь Төслийг Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөний (“БОНУАТ”) дагуу, Банкны шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэхийг баталгаажуулна:
 - (a) БОНУАТ-д заасан арга хэмжээ, үйл ажиллагаануудыг мөрдлөг болгон хэрэгжүүлж, мөн тус арга хэмжээнүүд нь БОНУАТ-д тусгагдсан байхад анхаарах;
 - (b) БОНУАТ-ийг хэрэгжүүлэх зардалд хангалттай хөрөнгө байлгах;
 - (c) БОНУАТ-нд заасан журам, горимыг мөрдөж, тус БОНУАТ-г хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадвартай, хангалттай тооны орон тоо байлгах; мөн
 - (d) БОНУАТ-нд заасны дагуу тус төлөвлөгөөний аль нэг заалтад Банктай бичгээр зөвшилцөлгүйгээр нэмэлт, өөрчлөлт оруулахгүй, хүчингүй болгохгүй, түдгэлзүүлэхгүй байх, мөн нэмэлт засвар оруулсан бол тус өөрчлөлтийг нэн даруй танилцуулах.
3. БОНУАТ болон тус Хэлэлцээрийн заалтууд хооронд аливаа зөрчил гарах тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн нөхцөл давуу үйлчилнэ.
4. Зээлдэгч дараах зүйлсэд анхаарна:
 - (a) БОНУАТ болон түүний дотор заасан байгаль орчин, нийгмийн хамгааллын хэрэгслүүдийг мөрдлөг болгож байгаа талаарх мэдээллийг БОНУАТ-нд заасан давтамжтайгаар тухай бүр Банканд хүргүүлэх арга хэмжээг авч, Банкнаас шаардсан тухай бүр тус мэдээллийг тусдаа тайлан эсвэл олон тооны тайлангаар хүргүүлэх бөгөөд тус тайлангуудыг Банкны шаардлагад нийцүүлэн, дараах мэдээллийг багтаасан байна: (i) БОНУАТ-ний хэрэгжилтийн байдал; (ii) БОНУАТ-ний хэрэгжилтэд саад болж байгаа эсхүл саад болж болзошгүй аливаа нөхцөл үүссэн бол тэдгээрийг заах; мөн (iii) тэдгээр нөхцөл байдлыг арилгахын тулд авч хэрэгжүүлсэн эсвэл хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тусгах; мөн
 - (b) Банканд Төсөлтэй холбоотой эсвэл төслийн хэрэгжилтэд нөлөөлж болохуйц осол, тохиолдол, мөн тус тохиолдол нь БОНУАТ болон түүнд заасан байгаль орчин, нийгмийн хамгааллын хэрэгсэл, Байгаль орчин нийгмийн хамгааллын стандартад заасны дагуу байгаль орчин, төсөл хэрэгжиж байгаа газрын иргэд, олон нийт, ажилчдад ноцтой сөрөг нөлөө үзүүлж болох талаар шуурхай мэдээллэсэн.

5. Зээлдэгч нь ашиглахад хялбар гомдол барагдуулах механизмыг байгуулж, энэ тухайгаа мэдээллэх ба, тус механизмыг ажиллуулан Төслийн нөлөөн дор байгаа хүмүүсийн гомдлыг хүлээж аван шийдвэрлэх бөгөөд, тэдгээр асуудал гомдлыг шийдвэрлэхдээ Банкны шаардлагад нийцүүлэн, бүх шаардлагатай арга хэмжээг авна.
6. Зээлдэгч нь Төслийн хүрээнд хийгдэж байгаа бүх барилгын ажлын тендерийн бичиг баримт, гэрээнүүд нь гэрээлэгч, дэд гэрээлэгч ба удирдан чиглүүлж байгаа байгууллагын үүрэг хариуцлагыг багтаасан байна. Үүнд: (а) БОНУАТ ба түүнд заасан байгаль орчин, нийгмийн хамгааллын хэрэгслүүдийн холбогдох хэсгүүдийг дагаж мөрдөх; ба (б) байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд ба аюулгүй байдлын эрсдэлүүд, бэлгийн дарамт ба хүчирхийлэл, хүүхдийн эсрэг бэлгийн дарамт хүчирхийллийн эрсдэлийг шийдвэрлэх арга хэмжээнүүдийг нарийвчлан заасан ёс зүйн журмыг боловсруулан, бүх ажилтнуудаас гарын үсэг зуруулан, мөрдүүлэх бөгөөд дээр дурдсан гэрээний дагуу хийгдэх барилгын ажлуудад ашиглана.

Д. Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ

1. Төслийн 4-р хэсэгт (Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний тухай бүрэлдэхүүн хэсэг) заасан ноцтой байдлын эсрэг авах арга хэмжээнүүдийн зохистой хэрэгжилтийг хангахын тулд, Зээлдэгч нь дараах зүйлсийг хийнэ:
 - (а) Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсгийн хэрэгжилтийн нарийвчилсан зохицуулалтыг тусгасан Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний гарын авлагыг (“ОБГА”) боловсруулан, Банкаар батлуулахаар хүргүүлэх бөгөөд үүнд: (i) Онцгой байдлын үед авах арга хэмжээг зохицуулж, хэрэгжүүлэх байгууллагын тусгай зохицуулалтууд; (ii) Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсэгт оруулж болох тусгай үйл ажиллагаанууд, үүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай Зөвшөөрөгдөх Зарцуулалтууд (“Онцгой байдлын зарцуулалт”), ба үүнтэй холбоотой процедурууд; (iii) Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний санхүүгийн удирдлагын зохицуулалтууд; (iv) Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсгийн худалдан авах аргачлал, процедур; (v) Онцгой байдлын зарцуулалтыг хийхэд шаардагдах бичиг баримт; (vi) Онцгой байдлын үед авах арга хэмжээнд Хамгааллын хэрэгслүүд болон бусад холбогдох хамгааллын хэрэгслүүдийг ашиглах; мөн (vii) Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний тухай хэсгийн зохицуулалт, хэрэгжилтийг хангахад шаардлагатай бусад зохицуулалтууд;



- (b) Банканд ОБГА-ыг үзэж танилцахад хангалттай цагийг олгох;
 - (c) Банкнаас зөвшөөрөл олгосон тохиолдолд ОБГА-ыг Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний тухай хэсгийн нэг хэсэг болгон нэн даруй батлах;
 - (d) Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний тухай хэсэг нь ОБГА-ын дагуу хэрэгжиж байгаад анхаарах; ОБГА болон энэхүү Хэлэлцээрийн хооронд аливаа зөрчил гарвал, тус Хэлэлцээрийн нөхцөлийг дагах; ба
 - (e) Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл аваагүй бол ОБГА-ын аль нэг заалтанд өөрчлөлт оруулахгүй, хүчингүй болгохгүй байх.
2. Зээлдэгч нь дараах нөхцөл байдал үүсэхээс нааш Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний тухай хэсгийн дагуу ямар нэг арга хэмжээ авахгүй:
- (a) Зээлдэгч нь Хүлээн зөвшөөрөхүйц хямрал, онцгой тохиолдол болсныг тогтоож, тус хямрал, онцгой тохиолдлын эсрэг авах арга хэмжээнүүдийг Онцгой байдлын үед авах арга хэмжээний тухай хэсэгт багтаах хүсэлтийг Банканд гаргаж, Банк тус тодорхойлолтыг хүлээн зөвшөөрөн, хүсэлтийг хүлээн авч Зээлдэгчид мэдэгдсэн; мөн
 - (b) Зээлдэгч нь ОБГА-ын дагуу тус арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүх хамгааллын хэрэгслүүдийг бэлтгэж, мэдээллэсэн байх, Банк тус хэрэгслүүдийг зөвшөөрч, Зээлдэгч нь тус хэрэгслүүдэд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байх.

II хэсэг. Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээ ба тайлагналт

- A.** Зээлдэгч нь Төсөл тус бүрийн тайланг хуанлийн хагас жил дууссаны дараа нэг сарын дотор багтаан тухайн хуанлийн хагас жилд хамаарах тайланг өгнө.
- Б.** **Дунд хугацааны үнэлгээ**
Зээлдэгч нь: (a) Хэлэлцээр хүчинтэй болсон өдрөөс хойш арван найм (18) сарын дотор Банканд дунд хугацааны тайланг бэлтгэж хүргүүлнэ. Ингэхдээ Банкнаас шаардаж болох мэдээллийг багтаан, тус тайланг гаргахаас өмнөх хугацаанд Төслийг хэрэгжүүлэхэд гарсан ахиц дэвшлийг баримтжуулж, энэхүү хэсгийн А хэсэгт заасны дагуу хэрэгжүүлэх хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг бодолцон үзэж, тус тайланг гаргаснаас хойших хугацаанд Төслийг амжилттай хэрэгжүүлэх, төслийн зорилтуудад хүрэхэд авч хэрэгжүүлж болох

арга хэмжээнүүдийг заана; мөн (b) тайланг хүргүүлснээс хойш дөчин таван (45) хоногийн дотор тус дунд хугацааны тайланг Банканд хамтран хянаж, дунд хугацааны тайлангийн дүгнэлт, зөвлөмж болон тухайн асуудлын талаарх Банкны байр суурьд үндэслэн Төслийн цаашид төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх, зорилтуудыг хангахад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- B.** Энэхүү Хэлэлцээрт тусгайлан заасан эсвэл Банкнаас шаардсанаас бусад тохиолдолд Зээлдэгч нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 1-т заасан үйл ажиллагаануудтай холбоотой аливаа мэдээлэл, тайлан эсвэл бичиг баримтыг хуваалцахдаа тус мэдээлэл, тайлан, бичиг баримтанд Хувийн нууцын мэдээлэл байхгүй байх тал дээр анхаарна.

III хэсэг. Зээлийн хөрөнгийн татан авалт

A. Ерөнхий зүйл.

Ерөнхий нөхцөлүүдийн II дугаар зүйл болон Татан авалтын болон санхүүжилтийн албан зааврын дагуу Зээлдэгч нь Зээлийн эх үүсвэрийг татан авч: (a) Зөвшөөрөгдсөн зардлыг санхүүжүүлэх; ба (b) дараах төлбөрийг хийх: (i) урьдчилсан шимтгэл; болон (ii) Хүүгийн дээд хязгаар буюу Хүүгийн шимтгэл; доорх хүснэгт дэх ангилал тус бүрд хуваарилагдсан зээлийн хэмжээ болон хамаарах санхүүжилтийн хувь хэмжээнд нийцүүлэн санхүүжилтийг татан авч Зөвшөөрөгдсөн зардлыг санхүүжүүлж болно:

Ангилал	Зээлийн хөрөнгийн хуваарилалт (ам. доллараар)	Санхүүжүүлэх зардлын хувь хэмжээ (Татвар орсон)
(1) Төслийн 2.1 хэсгийн бараа, ажил, зөвлөхийн бус үйлчилгээ, зөвлөхийн үйлчилгээ ба сургалт	13,765,500	100%
(2) Төслийн бүрэлдэхүүн хэсэг 4-ийн Онцгой байдлын зардлууд	0	100%
(3) Зээлийн шимтгэл	34,500	Ерөнхий нөхцөлийн 2.07 (b) хэсэгт зааснаар, тус Хэлэлцээрийн 2.03 хэсгийн дагуу төлөх ёстой дүн
(4) Зээлийн хүүгийн дээд хязгаар	0	Ерөнхий нөхцлийн 4.05 (c) хэсгийн дагуу төлөх ёстой дүн
НИЙТ ДҮН	13,800,000	

**Б. Санхүүжилт татан авах нөхцөл, хугацаа.**

1. Дээр дурдсан А хэсэгт заасгаас үл хамааран дараах тохиолдолд зээлийн хөрөнгийг зарцуулахгүй. Үүнд:
 - (a) Энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурахаас өмнө гарсан аливаа төлбөрийг санхүүжүүлэхгүй хэдий ч Ангилал (1)-т хамаарах 2020 оны 1-р сарын 1 болон түүнээс хойших хугацаанд нийт 2,100,000 ам. доллараас хэтрэхгүй гарсан Зөвшөөрөгдсөн зардлуудыг санхүүжүүлж болно; эсхүл
 - (b) Ангилал (2)-т багтсан Онцгой байдлын зардлуудад төлбөр хийхгүй боловч Банк тус тохиолдлыг хүлээн зөвшөөрч энэ тухайгаа Зээлдэгчид мэдэгдсэн, мөн тус зардалтай холбоотой дараах бүх болзлыг хангасан тохиолдолд төлбөр хийж болно:
 - (i) Зээлдэгч нь Хүлээн зөвшөөрөхүйц хямрал, онцгой тохиолдол болсныг тогтоож, тус хямрал, онцгой тохиолдлын эсрэг хариу арга хэмжээ авахын тулд хэрэгжүүлж болох арга хэмжээнүүдийг Онцгой байдлын үед авах арга хэмжээний тухай хэсэгт багтаах хүсэлтийг Банканд гаргаж, Банк тус тодорхойлолтыг хүлээн зөвшөөрөн, хүсэлтийг хүлээн авч энэ тухайгаа Зээлдэгчид мэдэгдсэн байх;
 - (ii) Зээлдэгч нь тус арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүх хамгааллын хэрэгслүүдийг бэлтгэж, мэдээллэсэн байх, мөн Зээлдэгч нь тус хэрэгслүүдэд заасан үйл ажиллагааг тус Хуваарийн I.Г ба I.Д хэсэгт заасны дагуу хэрэгжүүлсэн байх,
 - (iii) Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний тухай хэсгийг зохицуулах, хэрэгжүүлэх ажлыг хариуцаж байгаа байгууллагууд нь тус Хуваарийн I.Д хэсэгт заасны дагуу дээр дурьдсан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд хангалттай үр чадвартай ажилчид, нөөцтэй байх; ба
 - (iv) Зээлдэгч нь ОБГА-ыг Банкны шаардлагад нийцүүлэн баталж, Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний тухай хэсгийн хэрэгжилтийг хангах үүднээс ОБГА-ын нөхцлүүдийг тус Хуваарийн I.Д хэсгийн заалтуудын дагуу байлгах эсвэл шинэчлэн засварласан байх.
2. Төсөл дуусгавар болох өдөр 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдөр байна.

ХУВААРЬ 3

Зээлийн амлалтад уялдсан эргэн төлөлтийн хуваарь

Дараах хүснэгтэд Зээлийн үндсэн төлбөр хийгдэх өдрүүд болон тухайн төлбөр хийх өдөр тус бүр зээлийн хөрөнгөөс эргэн төлөгдөх хувь хэмжээг тогтоосон (“Төлбөрийн хувь хэмжээ”).

Зээлийн амлалттай уялдсан эргэн төлөлт

Үндсэн төлбөр хийглэх огноо	Төлбөрийн хувь хэмжээ
Жил бүрийн 4 дүгээр сарын 15 болон 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд 2025 оны 4 дүгээр сарын 15-наас эхлэн 2049 оны 10 дугаар сарын 15-н хүртэл	2 %

ХАВСРАЛТ

Тодорхойлолтууд

1. “Жилийн ажлын төлөвлөгөө болон төсөв” болон “ЖАТТ” товчлол нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.B хэсэгт дурьдсан, төлөвлөгөө болон төсвийг хэлнэ; энэхүү төлөвлөгөөг Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр тухай бүр өөрчлөх боломжтой.
2. “Авилгын эсрэг журам” гэж Ерөнхий нөхцөлүүдийн Хавсралт дахь 5 дугаар хэсэгт заагдсан 2006 оны 10 дугаар сарын 15-нд батлагдсан, 2011 оны 1 дүгээр сар болон 2016 оны 7 дугаар сарын 1-нд тус тус шинэчлэгдсэн “Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны зээл болон Олон улсын хөгжлийн ассоциацийн зээл, буцалтгүй тусламжаар санхүүжих төслүүдэд баримтлах Луйвар, залилан, авилгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх журам”-ыг хэлнэ.
3. “Ангилал” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын III.A хэсэг дэх хүснэгтэд заагдсан ангиллыг хэлнэ.
4. “Коронавируст халдвар” гэж 2019 онд гарсан шинэ төрлийн титэм вирус (SARS-CoV-2)-ээс гаралтай титэм вирусын гаралтай өвчнийг хэлнэ.
5. “Онцгой байдалд авах хариу арга хэмжээний заавар” буюу “ГТХАХ” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.D.1-ийн (а)-д заасан зааврыг хэлэх ба Зээлдэгч энэхүү хэсэгт дурдсаны дагуу Онцгой байдалд авах хариу арга хэмжээний зааврыг батлан мөрдүүлнэ.



6. “Хамаарах хямрал эсхүл онцгой байдал” гэж Зээлдэгчид эдийн засгийн ба/эсхүл нийгмийн ихээхэн сөрөг нөлөө үзүүлсэн эсхүл үзүүлэхүйц, байгалийн болоод хүний хүчин зүйлээс хамааралтай хямрал эсхүл гамшгийг хэлнэ.
7. “Онцгой байдлын зардал” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.Д-ийн дагуу Онцгой байдалд авах хариу арга хэмжээ бүрэлдэхүүн хэсгийн дагуу онцгой байдлын үед гарах хамаарал бүхий аливаа зардлыг хэлнэ.
8. “Онцгой байдалд авах хариу арга хэмжээ бүрэлдэхүүн хэсэг” гэж төслийн Бүрэлдэхүүн хэсэг 4-ийн хүрээнд хямрал эсхүл онцгой байдалд авч хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ эсхүл үйл ажиллагааг хэлнэ.
9. “Байгаль орчин, нийгмийн хамгааллын төлөвлөгөө” эсхүл “БОНХТ” гэж төслийн зориулалтаар 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр баталсан, холбогдох заалтын дагуу тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой байгаль орчны болон нийгмийн хамгааллын төл өвлөгөөг хэлэх ба үүнд төслийн хэрэгжилтээс үүдэн байгаль орчин, нийгэмд учирч болзошгүй эрсдэл, нөлөөллийг шийдвэрлэх зорилгоор авч хэрэгжүүлэх биет арга хэмжээ, үйл ажиллагаа буюу тэрхүү арга хэмжээг авч хэрэгжүүлэх цаг хугацааны, институцийн, хүн хүчний, хяналт-шинжилгээ, тайлагналын зохицуулалтууд болон байгаль орчин, нийгмийн хамгааллын хувьд бэлтгэх шаардлагатай аливаа арга хэрэгслийг тусгасан байна.
10. “Байгаль орчин, нийгмийн стандарт” буюу “БОНС” гэж 2018 оны 10 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж буй Банкнаас хэвлэн гаргасан дараах стандартуудыг нийтэд нь хэлнэ: Үүнд: (i) “Байгаль орчин, нийгмийн стандарт 1: Байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ”; (ii) “Байгаль орчин, нийгмийн стандарт 2: Хөдөлмөрийн ба ажиллах нөхцөлүүд”; (iii) “Байгаль орчин, нийгмийн стандарт 3: Нөөцийн зохистой ашиглалт, бохирдлоос сэргийлэх, удирдах”; (iv) “Байгаль орчин, нийгмийн стандарт 4: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал”; (v) “Байгаль орчин, нийгмийн стандарт 5: Газар эзэмшил, газар ашиглалтын хязгаарлалтууд, албадан нүүлгэлт”; (vi) “Байгаль орчин, нийгмийн стандарт 6: Биологийн төрөл зүйлийн хамгаалалт, амьд байгалийн нөөцийн тогтвортой удирдлага”; (vii) “Байгаль орчин, нийгмийн стандарт 7: Үндэсний цөөнх/Сахарын цөл орчмын орон нутгийн иргэдийн уламжлалт ялгаварлалт”; (viii) “Байгаль орчин, нийгмийн стандарт 8: Соёлын өв”; (ix) “Байгаль орчин, нийгмийн стандарт 9: Санхүүгийн зуучлал”; (x) “Байгаль орчин, нийгмийн стандарт 10: Оролцогч талуудын оролцоо болон мэдээллийг нээлттэй болгох”.

11. “Санхүүжилтийн хэлэлцээр” гэж Зээлдэгч болон Ассоциаци хооронд төслийн хүрээнд байгуулсан, энэхүү Хэлэлцээртэй адилхан огноо бүхий, тухай бүр шинэчлэх боломжтой Хэлэлцээрийг хэлнэ. “Санхүүжилтийн хэлэлцээр” гэдэгт уг Санхүүжилтийн хэлэлцээрийн бүх хавсралт, хуваарь болон нэмэлт хэлэлцээрүүд мөн хамаарна.
12. “Ерөнхий нөхцөлүүд” гэж ОУХА-ийн Санхүүжилтийн Ерөнхий нөхцөлүүд буюу 2018 оны 12 дугаар сарын 14-нд батлагдсан Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн Ерөнхий нөхцөлүүдийг хэлнэ.
13. “СЯ” гэж Зээлдэгчийн Сангийн яам эсхүл түүний чиг үүргийг залгамжлагч байгууллагыг хэлнэ.
14. “ХХААХҮЯ” гэж Зээлдэгчийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам эсхүл түүнийг чиг үүргийг залгамжлагч байгууллагыг хэлнэ.
15. “ЭМЯ” гэж Зээлдэгчийн Эрүүл мэндийн яам эсхүл түүний чиг үүргийг залгамжлагч байгууллагыг хэлнэ.
16. “ОШХ хөтөлбөр” гэж Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, оношлох, хариу арга хэмжээ авах болон олон нийтийн эрүүл мэндийн бэлэн байдлыг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд зориулж Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциацийн гишүүн орнуудад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий олон шатлалт хөтөлбөрийг хэлнэ.
17. “Хувь хүний тоон мэдээ” гэж тухайн хүн эсхүл хувь хүнд хамаарах аливаа мэдээллийг хэлнэ. Хувь хүн гэж шууд болон шууд бус байдлаар тодорхой өгөгдөл, эсхүл түүний хослол, эсхүл тэрхүү өгөгдлийн бусад өгөгдсөн мэдээллийн нэгдлийн тусламжтай танигдах боломжтой хүнийг хэлнэ. Хувь хүнийг танихад нэр, таних дугаар, байршлын мэдээлэл, онлайн таних тэмдэг, мета өгөгдөл, тухайн хүний физик, физиологи, удамшлын, сэтгэцийн, эдийн засгийн, соёлын эсвэл нийгмийн хүчин зүйлд хамаарах өгөгдлүүдийн тусламжтай таних боломжтой ба эдгээрээр хязгаарлагдахгүй.
18. “Худалдан авах ажиллагааны журам” гэж Ерөнхий нөхцөлүүдийн Хавсралт дахь 85 дугаар зүйлийн дагуу 2016 оны 7 дугаар сард батлагдаж, 2017 оны 11 дүгээр сар, 2018 оны 8 дугаар сард тус тус шинэчилсэн “Дэлхийн банкны Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилттэй худалдан авах ажиллагаанд Зээлдэгчийн баримтлах журам”- ыг хэлнэ.
19. “Төсөл хэрэгжүүлэх заавар” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын Бүлэг I.Б-д тусгагдсан төслийг хэрэгжүүлэх зорилгоор Зээлдэгчийн баталсан зааврыг хэлэх ба үйл ажиллагаа болон ажлын горимын дараах дэлгэрэнгүй зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:



- (а) институцийн зохицуулалт, төслийн өдөр тутмын гүйцэтгэл; (б) зарцуулалт болон санхүүгийн удирдлага; (в) худалдан авах ажиллагаа; (г) байгаль орчин, нийгмийн нөлөөллийн арга хэмжээнүүд; (д) хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагнал ба харилцаа холбоо; (е) шударга ажиллагааны төлөвлөгөө, (ё) хувь хүний тоон мэдээлэл цуглуулах, мэдээлэлд олон улсын шилдэг туршлагын дагуу боловсруулалт хийх, төслийн хэрэгжилтийн хувьд хүлээх чиг үүрэг; (ж) Төсөлд шаардлагатай бусад захиргааны, санхүүгийн техникийн болон зохион байгуулалтын заавар, горим; энэхүү зааврыг Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр тухай бүр өөрчлөлт оруулж болох бөгөөд үүнд энэхүү зааврын аливаа хуваарь мөн хамаарна.
20. “Төсөл хэрэгжүүлэх нэгж” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.A.2.(б) хэсэгт зааснаар Зээлдэгчийн үүсгэн байгуулж, ажиллуулах нэгж эсхүл түүний чиг үүргийг залгамжлагчийг хэлнэ.
21. “Төслийн удирдах хороо” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.A.2.(б) хэсэгт зааснаар Зээлдэгчийн байгуулж, ажиллуулах хороо эсхүл түүний чиг үүргийг залгамжлагчийг хэлнэ.
22. “Хэлэлцээр байгуулсан өдөр” гэж Зээлдэгч ба Банк хооронд энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан хоёр огнооны сүүлийн огноог хэлэх ба энэхүү тодорхойлолт нь Ерөнхий нөхцөлүүдэд дурдагдсан “Хэлэлцээр байгуулсан өдөр” гэсэн заалт бүрд хамаарна.
23. “Сургалт” гэж төслийн хүрээнд хийгдэх аливаа сургалтын үйл ажиллагаа, семинар, сургалтын аялалд хүмүүсийг оролцуулахад шаардагдах бараа материал, үйлчилгээний боломжит зардлыг хэлэх бөгөөд үүнд сургалтад оролцогсдын унаа, байр хоолны зардал, сургагч багшийн үйлчилгээний хөлс, сургалтын байрны түрээс, сургалтын материал боловсруулах, олшруулах зардал болон семинар эсхүл сургалтын аялал зохион байгуулах, тэдгээрт оролцохтой холбоотой бусад шууд зардлууд орох ба гагцхүү зөвлөхийн үйлчилгээний хөлс, зөвлөхийн цалин, урамшуулал, мөнгөн шагнал, Зээлдэгчийн төрийн албаны цалин, хөлсөд дүйцэх зардлууд багтахгүй.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 3

Индекс: 200003